

ШИНЖЛЭХ УХААНЫ СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ
АСУУДАЛД

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: Шинжлэх ухааны сэтгүүл зүй, шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүл зүй, мэдээллийн шинэ технологи, шинжлэх ухааны блог, эрүүл мэндийн сэтгүүл зүй, сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх үүрэг

Сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн практикт идэвхтэй нэвтэрч буй нэр томъёоны нэг бол “шинжлэх ухааны сэтгүүл зүй” юм. Энэ нэр томъёо бидний үгийн санд хэдийгээр хожим орж ирсэн боловч цоо шинэ зүйл биш бөгөөд Монголын сэтгүүл зүйд олон арван жилийн турш түүний оронд “шинжлэх ухаан танин-мэдэхүйн нийтлэл/нэвтрүүлэг”, “шинжлэх ухааны хялбаршуулсан нийтлэл/нэвтрүүлэг” гэсэн нэр томъёог түгээмэл хэрэглэж ирсэн, одоо ч хэрэглэсээр байна. Ер нь шинжлэх ухаан танин-мэдэхүйн сэдэв Монголын сэтгүүл зүйд эртний уламжлалтай юм. Монголын ууган тогтмол хэвлэл болох “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудад шинжлэх ухаан-танин мэдэхүйн асуудлыг хөндсөн цөөнгүй нийтлэл гарч байсныг судлаачид нэг биш удаа тэмдэглэсэн байдаг. “Монголын тогтмол хэвлэлийн нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж: уламжлал, шинэчлэл” сэдвээр сэтгүүл зүйн докторын зэрэг хамгаалсан залуу

судлаач Н.Ариунзаяа: “Монголын ууган тогтмол хэвлэл, “Шинэ толь бичиг”-ийн хамгийн үнэтэй уламжлалын нэг нь соён гэгээрүүлэх шинж юм. ...Монголын анхны хэвлэлүүд дэлхий нийтийн жишгээс нэг л шинжээрээ гоц гойд ялгардаг. Дэлхий дахины, тэр тусмаа суурин соёл иргэншилтэй улс үндэстний сонин хэвлэл цаг үеийн мэдээллийг шуурхай түгээх зорилгоор үүссэн байдаг. Гэтэл Монголын анхны тогтмол хэвлэл мэдээлэл түгээхээсээ илүү соён гэгээрүүлэх, тодорхой хэлбэл шинжлэх ухааны суртал нэвтрүүлэг хийх зорилгоор үүссэн юм. Энэ нь тодорхой учир шалтгаантай байжээ. Юуны өмнө удам дэлгэр нутагтай, тархай бутархай нүүдлийн амьдралтай, дэд бүтэц огт байхгүй, хүн амын олонх нь бичиг үсэг мэдэхгүй байсан нөхцөлд сонины мэдээг шуурхай хүргэх ямар ч боломжгүй байв. Сонин гаргагчид энэ байдлыг харгалзан хуучирдаггүй мэдлэг, мэдээлэл болох шинжлэх ухааны суртал нэвтрүүлэгт гол анхаарлаа хандуулсан байна”¹ гэсэн зөв зүйтэй дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Мөн доктор, профессор Т.Баасансүрэн “Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаарт нийтлэгдсэн эрхлэгч Ж.Цэвээний “Элдэв ухааныг бадруулсан бичиг” хэмээх сонордуулгад тусгасан сонины бодлогыг тодорхойлох Ертөнцийн эл-

дэв байдал, Дэлхий дээрх олон улсын тус тусын байдал, Дэлхий дээрх хүмүүн төрөлхтний балар эрт цагаас янагш улам улмаар аж төрсөн ба ухааны эрдэм боловсорсоор ирсэн түүх, Монгол ба бусад олон улсын түүх, Тооны ба тод шинжлэх ухаан, Элдэв дүрс бодисын шинжлэх ухаан, Элдэв зүйлийн гайхамшигт цадиг түүх, Аж төрөхийг засах ба хүний бие сувилахуйн зүйл гэсэн 8 сэдэвт дүн шинжилгээ хийж: “Эл найман зүйл зорилтыг нягтлан шинжилж үзвээс тухайн үеийн хоцрогдсон феодалын Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааныг дэлгэрүүлэн түгээж, үр шимийг нь хүртэх явдал туйлын ач холбогдолтой гэж сониныхон үзсэн нь маш тодорхой мэдрэгдэж байна. Найман зүйл нийтлэлийн зорилтын бараг тавд нь шинжлэх ухааны аль нэг салбар чиглэлийг нэрлэн заажээ. Өөр нэг зорилт нь дэлхийн бусад улс орны байдал, тэдний хөгжин боловсорч ирсэн түүхийг түлхүү сурталчлах явдал байсан нь мөн илэрхий ажиглагдаж байна”² гэсэн дүгнэлт хийж, сонин соён гэгээрүүлэх шинжийг тодруулжээ. Үнэхээр “Шинэ толь хэмээх бичиг” сонин анхны дугаараасаа эхлэн “Ертөнцийн байдал төлөв” цуврал, “Тэнгэрийн дуу, цахилгааны учир”, “Хүний шүтэхбус шашны учир”, “Хүний насны учир”, “Ертөнцүүдийн анх тогтсоны учир”, “Гол дундах нарны ба бусад аймгийн явдал”, “Сар, нарны баригдахын учир” зэрэг цөөнгүй шинжлэх ухааны хялбаршуулсан өгүүлэл, тайлбар, мэдээ нийтэлсэн нь шинжлэх ухааны асуудалд гол анхаарлаа хандуулж байсны илрэл юм. “Шинэ толь хэмээх бичиг” сонин энэхүү соён гэгээрүүлэх чиглэлийг “Нийслэл хүрээний сонин бичиг”-ээс эхлээд хувьсгалт тогтмол хэвлэлүүд, ялангуяа “Багш нарын сэтгүүл” (1930), “Шинэ толь”

(1935), “Эрүүл мэнд” (1959), “Шинжлэх ухаан амьдрал” (1966), “Дорно дахины судлалын асуудал” (1978), “Анагаах ухаан” (1980), “Залуу зохион бүтээгч” (1981), “Эдийн засгийн боловсрол” (1983), зарим их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг зэрэг олон тогтмол хэвлэл тууштай үргэлжлүүлж, өдөр тутмын болон долоо хоногийн сонинууд шинжлэх ухаан-танин мэдэхүйн тогтмол булантай байсан уламжлалтай. Энэ бүхэн нь шинжлэх ухааны сэтгүүл зүй Монголын сэтгүүл зүйн хувьд шинэ зүйл биш бөгөөд түүнийг янз бүрийн арга хэлбэр, чиглэлээр тодорхой түвшинд хөгжүүлж өнөөдөрт хүрсний тодорхой жишээ мөн.

Шинжлэх ухааны сэтгүүл зүй (Science journalism/Science communication) гэдэг бол сэтгүүл зүйн тусгай салбар бөгөөд шинжлэх ухааны баримт, мэдээллийн үндсэн утга санааг өөрчлөхгүйгээр ОНМХ-ийн энгийн, ойлгомжтой нийтлэлийн хэл руу шилжүүлэх чиглэл юм. Шинжлэх ухааны сэтгүүл зүйг өргөн утгаар нь олон нийтэд шинжлэх ухааны ололт амжилт, түүний түүх, өнөөгийн байдал, хөгжлийн хэтийн төлөв, тулгамдсан асуудлуудын талаар энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх сэтгүүл зүйн түгээмэл чиглэл гэж ойлгож болно. Үндсэн сэдэв нь шинжлэх ухааны шинжтэй мэдээлэл байдаг. Шинжлэх ухааны баримт, мэдээллүүдийг өндөр түвшинд боловсруулж ОНМХ-ээр дамжуулан олны хүртээл болгох зорилготой. Шинжлэх ухааны сэтгүүл зүйд сүүлийн үед эрчимтэй хөгжиж буй чиглэл болох экологийн, эрүүл мэндийн, уул уурхайн зэрэг сэтгүүл зүйн олон чиглэл багтдаг. Мэдээллийн шинэ технологи, шинэ медиагийн үр дүнд шинжлэх ухааны

сэтгүүл зүйн шинэ хэлбэр болох шинжлэх ухааны блог, шинжлэх ухааны мэдээллийн агентлагууд үүсч, зарим оронд эрчимтэй хөгжиж байна.

Оросын нэрт эрдэмтэн, соён гэгээрүүлэгч М.Ломоносов шинжлэх ухааны сэтгүүл зүйн эх суурийг тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Тэрээр “Философийн эрх чөлөөг дэмжих зорилгоор зохиох, бичих үед баримтлах сэтгүүлчдийн үүргийн тухай эргэцүүлэл” (1755) хэмээх бүтээлдээ анх шинжлэх ухааны сэтгүүлчдийн баримтлах дараах зарчим, тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байдаг. Энэ бол:

- Бүтээлийн дотоод логикийг зөв оновчтой хийх;
- Зохиогчийн санаа бодлыг түүнд нарийн уялдуулж өгөх;
- Хэл найруулга нь амьд сонирхолтой байх;
- Ямар ч асуудалд хариуцлагатай, нямбай хандах;
- Бусдын санаа бодол, дүгнэлтийг хулгайлахгүй байх;
- Бусдыг шүүмжлэхийн тулд няцаалт хийх үндэслэлээ зөв гаргах;
- Өөрийнхөө давуу талыг ашиглан, дүгнэлт санаа бодлоо бусдаас дээгүүрт тавихгүй байх³ зэрэг юм.

Нэрт сэтгэгч М.В.Ломоносовын бодлоор сэтгүүл зүй бол үйл ажиллагааны онцгой төрөл учраас үнэнд чиглэгдсэн бүтээлч шинжтэй, сэтгүүлч боловсролтой, даруу төлөв зантай байхын хамт юу хийхээ урьдчилж шийдэх ёсгүй ажээ. Хэдийгээр дээрх санал үнэлэлт дүгнэлтэд сэтгүүлчийн нийгмийн үүргийн зарим шинжийн талаар тодорхой дурдсан боловч сэтгүүл зүй ба сэтгүүлчийн нийгмийн үүргийн талаарх шинжлэх ухааны үндэстэй томъёолол, тодорхойлолт нь нэлээд хожим бий болжээ.

Энэ үед хүмүүсийн сонирхлыг онцгой татаж байсан асуудал бол тогтмол хэвлэл ба түүний уншигчдын хоорондох харилцаа холбооны асуудал байв. Соён гэгээрүүлэгчдийн хувьд уншигчдад нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл бол эх бичвэрийг утга санаа, хэл найруулгын талаас төгс боловсруулах явдал гэж үздэг байжээ. Ийм хандлагыг Г.Лессинг, М.Ломоносов, Г.Миллер нарын бүтээлүүдээс харж болно.

Шинжлэх ухааны хялбаршуулсан нийтлэл бичих сэтгүүлчийн гол үүрэг нь соён гэгээрүүлэх үүрэг юм. Тиймээс сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх (танин мэдүүлэх) үүрэг бол ОНМХ-ийн системд онцгой байр эзэлдэг. Энэ үүрэг нь олон нийтийг нийгмийн ач холбогдолтой мэдлэг, үнэт зүйлсийг агуулдаг шинжлэх ухаан, соёл, урлаг зэрэг бүтээлч ажиллагааны тусгай салбарын олон түмэн ямар нэгэн шалтгааны улмаас хараахан мэдэж, эзэмшиж амжаагүй зүйлийг тусгасан сэтгүүлчийн бүтээлээр хангах, түүнд нийгмийн хөгжлийн чиг хандлагын онцлогийг харгалзан дүн шинжилгээ хийхэд оршино.

Сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх үүрэг нь үйл ажиллагааны мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, шүүмжлэх зэрэг хэрэгслүүдийн тусламжтайгаар амьдралд хэрэгждэг. Шинжлэх ухааны сэвээр мэргэшсэн сэтгүүлчийн үүрэг нь шинжлэх ухааны салбарт болж байгаа үйл явдал, баримтыг зөвхөн мэдээлэх зорилгоор хязгаарлах ёсгүй. Хамгийн гол нь сэтгүүлч соён гэгээрүүлэх шинжтэй шинжлэх ухааны хялбаршуулсан нийтлэл бичихдээ юуны өмнө шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгчийн үүргийг гүйцэтгэх учиртай. Шинжлэх ухааны сэдвийг голлон тусгадаг ОНМХ-ийн соён гэгээрүүлэх үүргийг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь түгээн

дэлгэрүүлэх үйл ажиллагаа болдог. “Түгээн дэлгэрүүлэх” хэмээх ойлголт нь нарийн төвөгтэй, ойлгох, хүлээж авахад хүндрэлтэй бүтээлийг агуулга, утга санааг өөрчлөхгүйгээр энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй болгон хувиргах үйл ажиллагааг илэрхийлдэг.

Орчин үеийн сэтгүүл зүйн тусгах сэдвийн хүрээ өргөжиж, өдөр тутмын ахуй амьдралын мэдээллээс гадна

олон асуудалд, түүний дотор шинжлэх ухаан, техникийн асуудалд хандах нь нэмэгдсээр байна. Үүний шалтгаан нь ихэнх хөгжингүй оронд удирдлагын ардчилсан зарчмууд өргөн дэлгэрч, олон түмэн ямар ч мэдээллийг хүлээж авах эрх чөлөө эдлэх болсонтой холбоотой юм. Харин төр тэднийг хүссэн мэдээллээр нь хангах үүрэгтэй. Сэтгүүл зүй, мэдээллийн харилцааг судалдаг эрдэмтдийн ихэнх нь ОНМХ бол хүлээн авагчид хүрээлж буй ертөнцийг таньж мэдэх, хүн төрөлхтний үнэт

зүйлсийг ойлгох, соёлыг түгээн дэлгэрүүлэх, бие хүн болон нийгэмших, боловсрол, хүмүүжилд нь нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрч, нийгмийн үйл явцыг удирдах, иргэдийн нийгмийн хамгаалал, хувь хүн болгоныг шаардлагатай мэдээллээр хангахад ОНМХ хяналтын болон зохицуулах үүрэгтэйгээс гадна сэтгүүл зүйн

зугаацуулах үүргийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байдаг.

Сэтгүүл зүйн танин мэдүүлэх (соёл-боловсролын) үүрэг нь хэдийгээр гол үүргүүдийн нэг боловч бусад үүргүүд шиг хатуу прагматик чиглэлтэй биш юм. Түүний зорилго нь хүний дотоод ертөнцийг баяжуулахад оршино. Нийгмийн сонирхдог соёлын хүрээний дотор гол төлөв нэгдүгээр байрт нь

уран сайхны соёл ордог бөгөөд түүний дараа суурь болон хавсарга шинжлэх ухаан, техник технологийн янз бүрийн салбар багтдаг байна. Энэхүү уран сайхны болон шинжлэх ухаан техникийн соёл бол сонин сэтгүүл, радио, телевизийн, Интернэт сүлжээний уран сайхны, шинжлэх ухааны хялбаршуулсан, танин мэдэхүйн болон боловсролын булан, хөтөлбөрийн судлагдахуун болдог. Сүүлийн үед дэлхий дахинд шинжлэх ухааны сэтгүүл зүйд ихээхэн анхаардаг

болсон шалтгаан нь нийгэм өдрөөс өдөрт асар их хэмжээний мэдээлэл хүлээж авч, хэрэглэдгийн тодорхой хэсэг нь шинжлэх ухааны шинжийг агуулах болсонтой холбоотой юм.

Олон нийтийн харилцааны бүтээгдэхүүний багагүй хэсгийг шинжлэх ухааны асуудлууд эзэлдэг. Сүүлийн хориод жилд сэтгүүл зүйд шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорил-



Орчин үед мэргэжлийн болон мэргэжлийн бус хүмүүсийн хоорондох зааг ялгааг багасгахад шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүлүүд тусалдаг. Заримдаа цэвэр шинжлэх ухааны асуудлуудыг төрөлжсөн мэргэжлийн сэтгүүлүүд бус нийгэм-улс төрийн нийтлэг хэвлэлүүдэд шүүн хэлэлцэж, маргаан мэтгэлцээн өрнүүлдэг нь энгийн үзэгдэл юм. Энэ бол нийгмийн төрөлжсөн мэдээллийн хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг илэрхийлэх бас нэг чухал хүчин зүйл мөн.



готой шинжлэх ухааны хялбаршуулсан чиглэл улам тод илрэх болсон. Орчин үед мэргэжлийн болон мэргэжлийн бус хүмүүсийн хоорондох зааг ялгааг багасгахад шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүлүүд тусалдаг. Заримдаа цэвэр шинжлэх ухааны асуудлуудыг төрөлжсөн мэргэжлийн сэтгүүлүүд бус нийгэм-улс төрийн нийтлэг хэвлэлүүдэд шүүн хэлэлцэж, маргаан мэтгэлцээн өрнүүлдэг нь энгийн үзэгдэл юм. Энэ бол нийгмийн төрөлжсөн мэдээллийн хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг илэрхийлэх бас нэг чухал хүчин зүйл мөн.

Шинжлэх ухааны сэтгүүл зүй бусад чиглэлээс мэргэжлийн үг хэллэг, нэр томъёог ашиглах, уран сайхны өнгө аяс, сэтгэл хөдлөлийн элементийг ховор хэрэглэх, хавсарсан нийлмэл өгүүлбэр болон хэл найруулгын нарийн төвөгтэй бүтцийг хэрэглэх, дам яриаг түгээмэл ашиглах зэрэг шинжээрээ ялгаатай.

Аливаа хөгжингүй оронд шинжлэх ухаан бүх төрлийн судалгаа, шинжлэх ухааны үйл ажиллагааны төрлийг нэгтгэсэн, өөрийн гэсэн харилцааны хэрэгслүүдтэй хүчирхэг нийгмийн институт болдог онцлогтой. Энэхүү харилцааг бид шинжлэх ухааны харилцаа гэж нэрлэдэг бөгөөд тэр нь олон нийтийн харилцааны системд үл хамаарах өвөрмөц хэрэгсэл байдаг. Гэхдээ олон нийтийн харилцааны хэрэгслүүдийн хамт нэг техникийн бааз дээр амьдралд хэрэгждэг. Харин тэдний гол зорилго нь нийгмийн институт болох шинжлэх ухааны бие даасан, найдвартай, нэгдмэл байдлыг хангахад оршино. Энэ харилцаа нь шинжлэх ухааны үйл ажиллагааны субъект болох эрдэмтэдтэй шууд ба шууд бус харилцах хэлбэрээр хэрэгжиж, тухайн орчинд тэдэнтэй холбоо тогтоох хэрэгслийн үүргийг

гүйцэтгэдэг. Тэдний хамгийн гол онцлог нь чухам үүнд оршдог.

Шинжлэх ухааны шууд харилцааны сувгийн үүргийг зөвхөн төрөлжсөн шинжлэх ухааны сэтгүүлүүд төдийгүй шинжлэх ухааны бүтээлийн эмхэтгэл, нэг сэдэвт зохиол, товхимол, эрдмийн зэрэг горилсон бүтээлийн хураангуй, эрдэм шинжилгээний илтгэлүүд зэрэг эрдэм шинжилгээ-судалгааны хэвлэлүүд, мөн эрдэмтдийн хэвлэмэл болон цахим хэлбэрээр илэрхийлсэн онолын, эсвэл туршилтын судалгааны үр дүнг агуулсан бие даасан бүтээлүүд гүйцэтгэдэг.

Шинжлэх ухааны хэвлэлүүдийн сэдэв нь маш өргөн, хэмжээ хязгааргүй гэдгийг бид мэднэ. Тэд аль ч шинжлэх ухааны салбарын ямар ч асуудлыг хөндсөн байдаг. Онол, хууль, таамаглал, шинжлэх ухааны нээлтүүд, туршилтын үр дүн, судлаачдын туршлага, шинжлэх ухааны болон шинжлэх ухааны чиглэлийн үүсэл, ямар нэгэн асуудлын хүрээнд өрнөсөн маргаан, эсвэл шүүмж гэх мэт ямар ч асуудал байж болно. Мөн тодорхой нэг судалгааны арга зүй, шинжлэх ухааны чухал нээлтийн түүх, байгаль, нийгмийн хөгжлийн зүй тогтол, шинэ үзэгдлүүд, ямар нэгэн баримтыг шинэ байр сууринаас тайлбарласан бүтээлүүд нийтлэгддэг.

Шинжлэх ухааны хэвлэл бол шинжлэх ухааны хувьд онцгой чухал янз бүрийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, тал бүрээс нь гүнзгийрүүлэн судлахад нөлөөлөхүйц шинжлэх ухааны үйл ажиллагааны үр дүн болон хэрэгсэл мөн. Энэхүү шинжлэх ухааны хэвлэлээс гадна нийгмийг өнгөрсөн үеийн судалгаа болон шинжлэх ухааны өв сантай танилцуулах зорилго бүхий хэвлэлүүд бий. Тэднийг эх сурвалж судлалын хэвлэл гэж нэрлэдэг нь түгээмэл юм.

Төрөлжсөн тогтмол хэвлэл дэх шинжлэх ухааны бүтээлүүд гол төлөв тодорхой чиглэлийн буюу эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдэд зориулагдсан байдаг. Шинжлэх ухааны бүтээлүүдийн зохиогчид ч, уншигчид ч үндсэндээ судлаачид байдаг. Энэхүү хүлээн авагчдын хүчин зүйл нь эх бичвэрийн хэл найруулгын онцлогт нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны эх бичвэр мэргэжлийн нэр томьёо, үг хэллэг, янз бүрийн хүснэгт, диаграмм, бүдүүвч агуулдаг нь энгийн үзэгдэл байдаг. Шинжлэх ухааны нийтлэлүүд зөвхөн хэл найруулга төдийгүй бичлэгийн төрөл, зүйлээр ч ялгаатай. Судалгааны өгүүлэл, шүүмж, тойм, тайлбар, бүтээлийн хураангуй (аннотаци) зэрэг цөөхөн хэдэн бичлэгийн зүйлийн хүрээнд олны хүртээл болдог. Мөн хэмжээгээрээ, мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдлоороо ч ялгаатай юм.

Шинжлэх ухааны нийтлэлүүдийн гол зорилго нь шинжлэх ухааны мэдлэгийг эргэлтэд оруулах, эрдэмтэн судлаачдыг судалгааны явцын болон үр дүнгийн талаарх мэдээллээр хангах, судалгааны үр дүнг сурталчлах, тайлбарлах, шинжлэх ухааны нийгэмлэгийн доторх дотоод харилцааны үүргийг гүйцэтгэх замаар түүний бүтэц нэгжүүдийн харилцан уялдаа холбоог бэхжүүлэхэд нөлөөлж, нийгмийн институт болох шинжлэх ухааны үйл ажиллагааг хэвийн явуулах, хөгжлийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангахад оршино.

Төрөлжсөн тогтмол хэвлэлийн шинжлэх ухааны нийтлэлүүд бол цэвэр сэтгүүл зүйн бүтээл биш, харин шинжлэх ухааны цомтгогч интеграл бүтээгдэхүүн юм. Харин “шинжлэх ухааны сэтгүүл зүй” хэмээх ойлголтыг гол төлөв редакц, хэвлэлийн үйл ажиллагааг

өөртөө агуулсан шинжлэх ухааны бүтээлүүдийг түгээх харилцааны сувгуудын нийлбэр гэсэн утгаар ойлгодог нь түгээмэл юм.

Мэдээллийн орон зай дахь шинжлэх ухааны хүрээнийхэнд шинжлэх ухааны мэдээллийг хүргэдэг мэдээллийн үйлдвэрлэлийн өөр нэг төрөл бол сэтгүүл зүй мөн. Сэтгүүл зүй өөрийнхөө мэргэжлийн үйл ажиллагаагаараа нийгмийн амьдралд хоёр чухал зорилгыг биелүүлдэг. Нэг талаар, сэтгүүл зүй олон нийтийн мэдээллийн урсгалыг бий болгохын тулд нийгмийн янз бүрийн хүчнүүдийн оюуны хамтын ажиллагааг зохион байгуулагч, нөгөө талаар энэхүү мэдээллийн урсгалд зориулан эх бичвэрийн өвөрмөц хэв маягийг үйлдвэрлэдэг янз бүрийн бүтээлч ажлын нийлбэр болдог. Өөрөөр хэлбэл олон нийтэд үйл ажиллагааны аль нэг салбарын талаарх шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэдэг сэтгүүл зүйн бүтээлийг бэлтгэдэг. Үүнийг шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүл зүй гэж нэрлэдэг. Шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүл зүйн бүтээлүүд шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүлүүд ч, өргөн хүрээг хамарсан нийгэм-улс төрийн, чанартай, олон нийтийн тогтмол хэвлэлүүдэд ч нийтлэгддэг. Мөн шинжлэх ухааны хялбаршуулсан сэдэв радио, телевизийн нэвтрүүлгүүдэд, интернэт сэтгүүл зүйд, мэдээллийн агентлагийн хөтөлбөрт ч чухал байр эзэлдэг. Шинжлэх ухааны хялбаршуулсан эх бичвэрүүд олон нийтэд зориулагдсан бөгөөд энгийн, ойлгомжтой байхын зэрэгцээ шинжлэх ухааны мэдлэгийг тухайн олон нийтийн харилцааны сувгийн онцлогийг харгалзан шуурхай дамжуулахад чиглэгдсэн байдаг.

Шинжлэх ухааныг ОНМХ-ийн тусгах объект гэж үзэхдээ юуны өмнө шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүл зүйн судлагдахууны хүрээг оновчтой тогтоож, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох шаардлагатай юм. Энэ бол:

- Шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, тогтмолжуулахад онцгой анхаарах нь чухал. Сэтгүүлч шинжлэх ухааны мэргэжлийн хэлийг олон нийтэд зориулсан хүртээмжтэй, энгийн, ойлгомжтой хэл найруулгад “шилжүүлэх” замаар шинжлэх ухааны мэдлэгийг түгээгч болдог онцлогтой.
- Шинжлэх ухааны ажилтнууд бол шинжлэх ухааны үйл ажиллагааны субъект гэдгийг тод томруун гаргаж өгөх шаардлагатай. ХМХ зөвхөн шинжлэх ухааны салбарыг тусгах төдийгүй эрдэмтэн судлаачдаар дамжуулан шинжлэх ухааны янз бүрийн дэг сургуулийн онцлог, ололт амжилт, саад бэрхшээлийг тусгах ёстой.
- Шинжлэх ухааны баримт сенсац ч, шинжлэх ухааны шинэ чиглэлийн эхлэл ч болдог. Энэ бол шинжлэх ухааны нээлтээр батлагдсан, нийгмийн чухал ач холбогдолтой шинжлэх ухааны олны анхаарлыг татсан баримт, мэдээллийг цаг алдалгүй тусгаж бай шаардлагатай гэсэн үг.

Шинжлэх ухааны үйл ажиллагааны дээр дурдсан асуудлуудыг тусгах сэтгүүлчийн зорилго бол:

- Шинжлэх ухааны шинэ бүтээгдэхүүн, үйл явдал, үзэгдэл, баримтуудын талаар хүлээн авагчдад цаг алдалгүй мэдээлэх;
- Олон нийтэд шинжлэх ухааны бүтээгдэхүүний онцлог, мөн чанарыг мэдэх, эзэмшихэд нөлөөлөх, шинжлэх

ухааны хөдөлгөгч хүч болсон эрдэмтдийг танилцуулах;

- Шинжлэх ухааны үйл явдлын талаар хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээн өрнүүлэхэд нөлөөлөх;
- Шинжлэх ухааны субъект болох судлаачдад өөрсдийн ажлын талаар эргэцүүлэн бодох, шаардлагатай тохиолдолд судлаачийн байр сууриа эргэж харах, хянахад нөлөөлөх явдал юм.

ОНМХ-д шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн талаар үнэн бодитой тусгахын тулд сэтгүүлч тухайн нийтлэлийг зориулан бичиж байгаа уншигчдаас арай илүү мэдлэгтэй бай ёстой. Өөрөөр хэлбэл өөрийгөө байнга боловсруулах, мэдлэгээ тасралтгүй дээшлүүлж байх шаардлагатай. Эс тэгвэл шинжлэх ухааны дэвшлийг гүйцэх ямар ч боломжгүй юм. Юуны түрүүнд шинжлэх ухааны хялбаршуулсан бүтээлүүдийг, тэдний дотор шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлуудыг агуулдаг генетик, биоинженерчлэл, сансар судлал зэрэг салбарын асуудалд илүү их анхаарал хандуулах хэрэгтэй. Энэ нь наад зах нь тухайн сэдвийг болон нэр томъёог мэдэх, эзэмшихэд тусалдаг. Зав гаргаж судалгааны лабораториудад очиж судалгааны үйл явцыг өөрийн нүдээр үзэх, гироскопыг барьж, барокамерт орж, микроскопоор амёбыг харж, судлаачидтай ойроос харьцаж, эрдэм шинжилгээний хурал, семинар, нийтийг хамарсан лекцүүдэд оролцох нь мянга дахин сонссоноос илүү ашигтай, үр дүнтэй. Сэтгүүлч шинжлэх ухааны асуудлаар гүнзгий мэргэшээгүй ч хааяа нэг шинжлэх ухааны асуудлаар бичдэг бол шинжлэх ухааны судалгаатай танилцаж, тухайн салбарын талаарх мэдлэгийг байнга баяжуулж байх шаардлагатай.

Тиймээс орчин үед Барууны ОНМХ-д сэтгүүлч болгон шинжлэх ухааны талаар тодорхой мэдлэгтэй байхыг шаарддаг болсон. АНУ-ын Массачусетсийн технологийн хүрээлэнгийн дэргэдэх шинжлэх ухааны сэтгүүлчдийн хөтөлбөрийн захирал Бойс Ренсбергер (Boyse Rensberger) шинжлэх ухааны сэдвээр бичдэг сэтгүүлчдэд зориулан дараах зөвлөмжийг санал болгосон байдаг. Үүнд:

- Нэгдсэн цорын ганц шинжлэх ухааны арга гэж байдаггүй. Аливаа сайн шинжлэх ухаан байнгын маргаан мэтгэлцээний нөхцөлд ажилладаг, шинжлэх ухааны үнэн мэтгэлцээний явцад бий болдог. Тиймээс улиг болсон хэвшмэл зүйл, урьдчилж итгэж үнэмшихээс зайлсхийх шаардлагатай. Энэ нь төөрөгдөлд хүргэх сөрөг нөлөөтэй;
- Томьёолол нь ганц утгатай бус, өөртөө итгэлгүй байх нь шинжлэх ухаанд үнэнч байгаагийн шинж. Энэ бол эрдэмтэн судалгаагаа үргэлжлүүлэхэд нөлөөлөх хөшүүрэг болдог. Орчин үеийн судалгааны бүтээлүүд янз бүрийн утга санааг агуулдаг учраас мухардмал байдалд орох нь түгээмэл байдаг;
- Шинжлэх ухаан нотолгоо шаарддаг, ямагт өмнөхөөс илүү сайн нотолгоог олж болдог. Хэрэв тодорхой баталгаа нотолгоо байхгүй бол эрдэмтний нэр хүнд таныг итгүүлэн үнэмшүүлж чадахгүй. Баталгаа байхгүй бол итгэх хэрэггүй, бүр эрдэмтэнд ч итгэх шаардлагагүй;
- Судлаачаас ямар нэгэн эм тариа эсвэл багаж хэрэгсэл хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй (аюултай) эсэхийг асуух хэрэггүй. Учир нь зуун хувь аюулгүй зүйл гэж байдаггүй. Судалгааны эрсдэлтэй болон ашигтай

талын аль алиныг зөв үнэлж, тэнцвэрт байдлыг олох хэрэгтэй;

- Сэтгүүлчид ч, эрдэмтэд ч нэг л зорилгыг чухалчилдаг. Аль аль нь үнэнийг олох, түүнийг олны хүртээл болгохыг хичээдэг⁴.

Шинжлэх ухааны сэтгүүл зүй зөвхөн сэтгүүлчээс эсвэл ОНМХ-ийн редактораас шалтгаалахгүй. Энд сэтгүүлчид болон эрдэмтэн судлаачдын, сэтгүүл зүйн болон ОНМХ-ийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэйгээс гадна судлаачдын сэтгүүл зүйн тухай төсөөлөл, мэдлэг онцгой ач холбогдолтой юм.

Тэгвэл эрдэмтэн судлаачид сэтгүүл зүйн тухай чухам юу мэдэх ёстой вэ? Юуны өмнө сэтгүүл зүй бол мэргэжил бөгөөд аливаа мэргэжил өөрийн гэсэн онцлогтой, дүрэм журамтай, уран чадварын өөрийн гэсэн нууцтай байдгийг мэдэх нь чухал. Тиймээс эрдэмтэн сэтгүүлчид итгэх, өөртэй адилхан ярилцагч мөн гэдгийг олж харахаас гадна сэтгүүлчийн хөдөлмөрийн дараах онцлогийг мэдэх ёстой.

— Сэтгүүлч байнга яарч явдаг. Яагаад? Тэрээр материалаа тогтсон цагт өгөх ёстой, энэхүү цаг хугацаа нь гол төлөв хэдхэн цагаар л хязгаарлагддаг. Хэрэв судлаачид сэтгүүлч болж байгаа чухал үйл явдлын талаар ярилцлага эсвэл тайлбар авахыг хүссэн бол хариулт одоо, удлаа гэхэд хэдхэн цагийн дараа хэрэгтэй гэсэн үг. Учир нь сэтгүүлч нийтлэлээ ажлын цаг дуусахаас өмнө бэлэн болгох ёстой. Тиймээс эрдэмтэн юуны өмнө сэтгүүл зүйн энэ онцлогийг ямагт харгалзан үзэх шаардлагатай юм.

— Сэтгүүлчид эрдэмтдээс шинжлэх ухааны асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлахыг хүсдэг. Яагаад? Учир нь сэтгүүлч нэг талаар, эрдэмтдийн судалгааны тухай мэдэх-

гүй, нөгөө талаар шинжлэх ухааны нэр томъёог эзэмшээгүй байдаг. Тиймээс сэтгүүлчээс боломжгүй юмыг шаардах хэрэггүй. Орчин үед шинжлэх ухааны судалгаа улам нарийн төвөгтэй болж, ердийн амьдрал, орчноос улам холдсоор байгаа бөгөөд түүнийг тайлбарлаж бичихийн тулд жирийн олон түмэнд хүртээмжтэй бус, ойлгоход төвөгтэй тусгай хэл найруулга шаардлагатай болсон. Заримдаа шинжлэх ухааны салбарын хүмүүс хүртэл юуны тухай ярьж байгааг ойлгохгүй тохиолдол ч гардаг. Тиймээс эрдэмтэн судлаачид сэтгүүлчтэй энгийн яриа өрнүүлж, шинжлэх ухааны нэр томъёо, нарийн төвөгтэй мэргэжлийн хэллэгийг аль болох бага хэрэглэхийг хичээх хэрэгтэй.

— Шинжлэх ухааны сэдвээр бичдэг сэтгүүлчид алдаа гаргадаг нь түгээмэл байдаг. Энэ бол гол төлөв эрдэмтэн судлаачдын тайлбараас ямар нэгэн зүйлийг дутуу ойлгосон эсвэл тухайн сэдвээ дутуу судалснаас болдог. Тиймээс судлаач өөрийнхөө судалгааны ажлын талаар товч, тодорхой тайлбарлахын зэрэгцээ хамгийн гол санааг хэд хэдэн удаа давтаж хэлэх нь чухал байдаг. Сэтгүүлчээс ярьсан бүх зүйлийг ойлгосон, тухайн судалгааны нэр томъёо, судлагдахууны талаар асуух зүйл байгаа эсэхийг тодруулах нь нийтлэлийн чанарт эерэг нөлөө үзүүлдэг. Судлаач өөрийнхөө санаа бодлыг энгийн, маш тодорхой илэрхийлэхэд цаг харамлахгүй байх нь сайн нийтлэл гарах урьдач нөхцөл болдог.

— Сэтгүүлч яагаад нийтлэлийг мэргэжлийн судлаачаар биш өөрөө бичдэг вэ? Бичнэ гэдэг бол сэтгүүлчийн үндсэн ажил. Үүний төлөө түүнд мөнгө төлдөг. Ихэнх редакцад эх бичвэрт тавигдах онцгой шаардлага байдаг. Зөвхөн тухайн редакцад ажиллаж байгаа сэтгүүлч л материалыг сонин

хэвлэлд хэрэгтэй, үр ашигтай нийтлэл болгож чаддаг. Тиймээс сэтгүүлчийн ажлыг судлаач хийгээд хэрэггүй. Харин тодорхой, хангалттай мэдээлэл өгсөн дээр. Тэд судлаачаас шуурхай, бас илүү сайн материал бэлтгэж чаддаг.

— Сэтгүүлч яагаад “анхаарал татах” баримт, үйл явдалд дуртай байдаг вэ? ОНМХ гэдэг бол бизнес, сэтгүүлч бол худалдагч гэсэн үг. Тэр өөрийнхөө нийтлэлийг олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн худалддаг болохоос тэдэнд боловсрол олгохыг зорилго болгохгүй. Боловсролыг бүх шатны сургуулиуд олгодог. Сэтгүүлчийн зорилго нь үйл явдлын талаар мэдээлэл өгч, олон нийтийн анхаарлыг татахад оршино. Тиймээс судлаач сэтгүүлчийг тунгаан боловсруулсан, тодорхой мэдээллээр шаардлагатай хугацаанд нь хангах нь чухал юм.

— Судлаач өөрийнхөө ажлын талаар аль болох сонирхолтой, чин сэтгэлээсээ ярих шаардлагатай. Хэрэв судлаач өөрөө сонирхолтой, сэтгэл хөдөлгөх хэмжээнд ярьж чадахгүй бол сэтгүүлчээс их юм хүлээх хэрэггүй. ОНМХ бол олон нийтийн мэдлэгийн хүрээг өргөжүүлж, танин мэдүүлэх боломж учраас энэ боломжийг алдахгүй байхыг хичээх хэрэгтэй.

— Таны яриаг диктафонд бичиж байгаа учраас хариулт маш сайн тунгаан бодсон, хариуцлагатай хандсан байх ёстой. Маргааш сонинд гарахыг хүсээгүй зүйлийн талаар яриад хэрэггүй. Хэрэв та “үүнийг бичээд хэрэггүй шүү” гэж хэлсэн бол сэтгүүлч таныг зөв ойлгосон эсэхийг нягтлах шаардлагатай.

— Сэтгүүлчтэй хийсэн ярианаас өөртөө ашигтай зүйлийг авч үлдэхийг хичээ. Мэргэжлийн бус хүнд ойлгоход хүндрэлтэй ямар зүйл байв, сурвалж-

лагчийн анхаарлыг чухам ямар зүйл илүү ихээр татдаг вэ, таны агуу их таамаглал яагаад түүнийг “байлдан дагуулж чадаагүй вэ?” гэх мэт зүйлийг сайн ажиглах хэрэгтэй. Энэ туршлага дараа дараагийн сэтгүүлчидтэй ярилцах үед танд туслах болно.

Европ болон АНУ-д шинжлэх ухааны сэтгүүл зүйг дээдсийн (элит) сэтгүүл зүй гэж үздэг нь санамсаргүй зүйл биш юм. Шинжлэх ухааны сэтгүүлчдийн ихэнх нь маш чадвартай Freelancer буюу чөлөөт сэтгүүлчид байдаг. Тэд өндөр цалинтай, нэр хүндтэй, ёс зүйтэй, өндөр хариуцлагатай хүмүүс байдаг бөгөөд мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, янз бүрийн тэтгэлэгт хөтөлбөрт (грант) тэднийг хамгийн түрүүнд хамруулдаг.

Сүүлийн жилүүдэд Барууны орнуудад шинжлэх ухааны сэтгүүлчдийг тусгайлан бэлтгэх асуудалд онцгой анхаардаг болсон. Ихэнх орны сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуульд шинжлэх ухааны сэтгүүл зүйн хичээлийг сонгон суралцах, мэргэшүүлэх хэлбэрээр оруулдаг. Тухайлбал, ХБНГУ-ын Дортмундын Их Сургуульд шинжлэх ухааны сэтгүүлчийг бакалаврын түвшинд дагнан бэлтгэдэг бол Англид 1993 онд тусгай хөтөлбөр баталж, шинжлэх ухаан ба нийгмийн харилцааг төрийн бодлогын нэг хэсэг болгон авч үздэг болжээ. Мөн Science communication-ний мэргэжилтэн бэлтгэх тусгай институт үйл ажиллагаа явуулдгаас гадна Английн Шинжлэх ухаан, технологийн департаментын дэргэд олон нийтэд шинжлэх ухааны ач холбогдлыг тайлбарлах, ойлгуулах, сурталчлах зорилготой тусгай комисс ажилладаг байна. 1998 онд “Шинжлэх ухаан ба нийгэм” хөтөлбөрийн хүрээнд “Alpha Galileo” нэртэй Европын хэвлэл мэдээллийн төв (пресс-центр) байгуулж, Европын

орнуудын шинжлэх ухааны мэдээллийг агуулдаг www.alphagalileo.org сайт ажиллуулж, ОНМХ-үүдэд пресс-релиз түгээдэг байна. Эрдэмтдээс 24 цагийн дотор шаардлагатай мэдээлэл авч түгээх зорилготой Хэвлэлийн төлөөлөгчдийн (пресс-секретарь) нийгэмлэг байгуулсан нь шинжлэх ухааны сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүнийг эрдэмтдийг ХМХ-д татах чухал арга гэж үздэг. Үүний үр дүнд “BBC” шинжлэх ухаан-танин мэдэхүйн хэд хэдэн хөтөлбөртэй болж, тусгай сувгуудыг нээж, “BBC National Geographic” суваг шинэ шатанд гарсан. Дэлхийд алдартай шинжлэх ухааны сэтгүүл болох “New Scientist”, “Nature” сэтгүүл эрс сайжирч, хэвлэгдэх хувь нь нэмэгдсэн. АНУ-ын Колумбын их сургуульд шинжлэх ухааны сэтгүүлчдийг бэлтгэх бакалаврын тусгай хөтөлбөртэй, геологич-сэтгүүлч гэсэн мэргэжлээр бэлтгэдэг. Сэтгүүлчдийг шинжлэх ухааны чиглэлээр мэргэшүүлэхэд “Scientific American” сэтгүүл чухал үүрэг гүйцэтгэдэг. 150 жил тогтвортой гарч байгаа энэ сэтгүүл нэг сая хувиар хэвлэгддэг. Дэлхийн бусад улс оронд ч олон арван хувилбартай. Impact Factor-ын 3.3 индекстэй. Дэлхийн шинжлэх ухааны хамгийн шилдэг 4 сэтгүүлийн нэг.

ОХУ-д Москвагийн ИС-ийн Сэтгүүл зүй болон Биологийн факультетэд шинжлэх ухааны сэтгүүл зүйн чиглэлийн тусгай хичээл заадаг. 2013 онд Москвагийн ОУХДС болон Москвагийн ИС-д шинжлэх ухааны сэтгүүл зүйн магистрантурыг нээсэн зэрэг олон жишээг иш татаж болно.

Европын орнуудын өдөр тутмын сонины нийтлэлд хийсэн судалгаагаар шинжлэх ухааны мэдээллийн 30%-ийг эрүүл мэнд, 22%-ийг хүрээлэн буй орчин, 13%-ийг биологи, 11%-ийг сансар

судлал... 1%-ийг математик эзэлдэг байна⁵.

Эрдэмтэд судалгааны үр дүнг олон нийтэд түгээх дөрвөн гол шалтгааныг:

- Улсын төсөвт мөнгөө өгч байгаа татвар төлөгчдийн өмнө эрдэмтэн-судлаачдын хүлээх хариуцлага;
- Залуучуудыг шинжлэх ухаанд татан оролцуулахад нөлөөлөх;
- Шинжлэх ухааны ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;
- Шинжлэх ухааны тулгамдсан асуудлуудын хүрээнд маргаан мэтгэлцээн өрнүүлэх, түүнд идэвхтэй оролцох гэж тодорхойлсон байдаг.

Манай орны хувьд шинжлэх ухааны сэтгүүл зүй гэсэн нэр томъёог харьцангуй бага хэрэглэдэг боловч шинжлэх ухаан, техник технологийн мэдээллийг ОНМХ-д тусгаж ирсэн олон жилийн уламжлалтай гэдгийг дээр дурдсан. 1990 он хүртэл ОНМХ-ийн шинжлэх ухааны булан, тусгай нэвтрүүлгээс гадна Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгээс эхлэн гаргадаг “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүл энэ асуудлыг голлон тусгаж ирсэн. Одоо энэ сэтгүүлийг ШУА-иас эрхлэн гаргаж байна. Мөн их, дээд сургуулиуд эрдэм шинжилгээний бичиг, тусгай сэтгүүл гаргаж байгаагийн зэрэгцээ томоохон телевиз, радио “Томьёо”, “Эрдэмтдийн индэр”, “Судлаачийн үг” зэрэг теле-сэтгүүл, тусгай булан ажиллуулж байна. Цаашид шинжлэх ухааны сэтгүүлчдийг тусгайлан бэлтгэх, эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн гаралтын давтамжийг нэмж, нийтийн захиалгад оруулах, шинжлэх ухаан танин мэдэхүйн бие даасан суваг, сонин, сэтгүүлтэй болох шаардлага хурцаар тавигдаж байна. Гэхдээ шинжлэх ухааны сэтгүүл зүйн өнөөгийн байдлыг өргөн хүрээнд авч үзвэл тийм ч баярлахааргүй дүр зураг

бууна. 1990-ээд оноос өмнөх үеийн энэ чиглэлийн ихэнх сэтгүүл хаагдсан, байгаа хэдийн хэвлэгдэх хувь нь хэд дахин багассан, радио, телевизэд шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлэг хуруу дарам цөөн, дээр нь мэргэшсэн боловсонгүйгээс шалтгаалан чанар нь эрс муудсан нь ажиглагддаг. Сэтгүүлчид шинжлэх ухаанаас илүү реклам, PR, энтертайнмент руу тэмүүлдэг болсон. Нөлөө бүхий өдөр тутмын сонин, МҮОНРТ хүртэл шинжлэх ухаан, танин мэдэхүйн алба, хэлтэсгүй болсон.

Цаашид шинжлэх ухааны сэтгүүлийг хөгжүүлэх боломж, энэ чиглэлийн нийтлэл, нэвтрүүлгийг улам боловсронгуй болгоход шийдвэрлэх шаардлагатай цөөнгүй асуудал байна. Тэдний заримаас нь тоймлон дурдвал:

- Манай радио, телевиз болон тогтмол хэвлэлд шинжлэх ухаан танин мэдэхүйн асуудлыг хөндсөн нийтлэл, нэвтрүүлэг, ялангуяа орчуулгын материал цөөн боловч тогтмолжих хандлагатай байна. Энэ бол дэмжүүштэй, эерэг үзэгдэл. Гэхдээ орчуулгын бүтээлийн хэл найруулгыг сайжруулах, энгийн ойлгомжтой, хүртээмжтэй болгох шаардлагатай байна.
- Орчин үеийн шинжлэх ухааны ололтыг хангалттай түвшинд сурталчилж, түгээн дэлгэрүүлж чадахгүй байна. Шинжлэх ухаан-танин мэдэхүйн бие даасан хялбаршуулсан тогтмол хэвлэл болон радио, телевизийн нэвтрүүлэг ховор байна. Шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч хуруу дарам цөөн. Телевизэд цөөн тооны эрдэмтэн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагыг эс тооцвол гол төлөв орчуулгын баримтат нэвтрүүлэг голлон гардаг. Чухал нээлт, шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн талаар ганцхан материалын хэмжээнд хүргэх

боломжтой учраас олон шат дамжлагыг дамжих шаардлагатай болдог. Тиймээс цуврал нэвтрүүлэг, нийтлэл гаргах боломж янз бүрийн шалтгааны улмаас ХМХ-д хомс байдаг.

- Хэрэв манай орны ОНМХ-үүд цэнгээнт хөгжөөнт нэвтрүүлэг эвэл улс төрийн сэдэвт гол анхаарлаа хандуулдаг бол Барууны орнуудад эсрэгээр олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлд түлхүү анхаарч, шинжлэх ухаан-танин мэдэхүйн сэдвийг чухалчилдаг. Тиймээс редакцууд өөрсдийн ажилтнуудыг захиалгаар нөлөө бүхий их, дээд сургуульд шинжлэх ухааны тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан бэлтгэх, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудад мэргэжил дээшлүүлэх, дадлага хийлгэх ажлыг тогтмол зохион байгуулах замаар шинжлэх ухааны сэтгүүлчдийг бэлтгэхэд түлхүү анхаардаг. Энэ бол манай ОНМХ-ийн редакцуудын анхаарлын төвд байх асуудал болж байна.
- Барууны ОНМХ-үүдийн редакцын анхаарлын төвд байдаг тулгамдсан асуудлуудын нэг бол шинжлэх ухааны сэдвээр бичдэг сэтгүүлчийн ёс зүй, хариуцлагын асуудал байдаг. Энэ асуудал өнөөдөр ганц сэтгүүл зүйн хувьд төдийгүй нийгмийн өмнө тулгамдсан асуудал болон хувирч байна. Учир нь шинжлэх ухаан хүн төрөлхтний хувьд нэг талаар аврагч, хамгаалагч, нөгөө талаар хор хөнөөл учруулагч байх нь энгийн үзэгдэл болон хувирсан. Тийм учраас нийгэм шинжлэх ухааныг яаж хүлээж авч байна, түүнийг шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүл зүй яаж тусгаж вэ гэдэг нь өөрөө онцгой чухал асуудал мөн.
- Америк болон Европын орнуудад Шинжлэх ухааны сэдвээр бичдэг

сэтгүүлчдийг элит сэтгүүлчдийн тоонд оруулдаг бөгөөд бичсэн нийтлэлийг маш өндөр үнэлдэг. Энэ нь нэг талаар, шинжлэх ухааны сэдвээр бичих нь сэтгүүлчээс асар их мэдлэг, боловсрол, дадлага туршлага шаарддагтай, нөгөө талаар үүнээс шалтгаа-лан шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн сайн сэтгүүлч харьцангуй ховор байдагтай холбоотой юм. Тиймээс шинжлэх ухааны сэдвээр бичдэг, нэвтрүүлэг бэлтгэдэг сэтгүүлчид гол төлөв freelancer буюу чөлөөт сэтгүүлч маягаар ажилладаг. Тэд сэтгүүлчийн мэргэжлээс гадна шинжлэх ухааны аль нэг чиглэлээр нарийн мэргэшсэн, гол төлөв магистр, докторын зэрэгтэй, туршлагатай хүмүүс байдаг. Өнөөдөр манай оронд шинжлэх ухааны сэтгүүл зүй хөгжихгүй байгаа нэг гол шалтгаан нь мэргэшсэн сэтгүүлч боловсон хүчин нэн ховор байгаатай, мөн сэтгүүлчийн хөдөлмөрийг, ер нь оюуны хөдөл-мөрийг үнэлэх систем бүрдээгүй байгаатай шууд холбоотой юм.

Хэрэв эрдэмтэн судлаачид өөрсдийн судалгааны үр дүнгийн талаар хүлээн авагчдад хүртээмжтэй, энгийн ойлгомжтой бичиж, ярьж чадвал шинжлэх ухааны сэтгүүл зүйг хөгжүүлэхэд томоохон алхам болох учиртай. Харамсалтай нь тийм боломж байхгүй гэж хэлж болно. Учир нь эрдэмтэд энгийн нийтлэлийн хэлээр бичиж сураагүйгээс гадна сонин сэтгүүлд юм бичих, нэвтрүүлэгт оролцох нь цаг алдах тул сонирхолгүй байдаг. Тэд эхний ажлын араас явж байхын оронд хоёр дахь ажлаа хийхийг илүүд үздэг. Тиймээс хүссэн эс хүссэн ч шинжлэх ухааны хялбаршуулсан материалыг шинжлэх ухааны тусгай мэдлэг эзэмшээгүй, судалгааны ажлын туршлагагүй

сэтгүүлчид бичихээс өөр аргагүй болдог. Тиймээс сэтгүүлчид шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн талаарх асар их мэдээллийн урсгалаас хамгийн чухал гэдгийг хэлж, сонгож, чиглүүлж өгдөг хүчин зүйл хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Үүнд юуны өмнө судалгааны байгууллагуудын хэвлэлийн бага хурал, сэтгүүлчдэд тараадаг пресс-релиз тус болдог. Энд судалгааны үр дүн яагаад чухал гэдгийг тайлбарлаж, ямар нэр томъёо ашиглахыг хэлж өгдөг. Гэхдээ бүх чухал, хэрэгтэй зүйл пресс-релизд ороогүй үлдсэн байх магадлал өндөр. Тиймээс янз бүрийн сэдвийг хөндсөн, орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтыг уг эх сурвалжид тулгуурлан хялбаршуулан тайлбарласан, бэлтгэлгүй уншигчдад тус болохуйц нийтлэлүүд болон тойм мате-риалуудыг агуулсан хараат бус мэргэжлийн мэдээллийн эх сурвал-жууд шаардлагатай болж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд олон шинжлэх ухааныг хамарсан өндөр түвшний шинжлэх ухааны хялбар-шуулсан сэтгүүлийг бий болгох шаардлагатай. Харин сэтгүүлийн агуулга нь харьцангуй бэлтгэлтэй уншигчдад зориулагдсан байх нь чухал юм. Үүнээс гадна тодорхой мэргэжлийн эрдэмтэд, их

дээд сургуулийн багш нарт зориулсан хялбаршуулан төрөлжсөн сэтгүүлийг ч олшруулах шаардлага бий. Ийм сэтгүүлүүд гаргахад санхүүгийн асуудал чухал гэдэг нь тодорхой. Үүнийг оновчтой менежментээр шийдэх боломжтой. Энэ асуудлыг англи хэлтэй орнуудад шинжлэх ухааны үр

дүнг түгээн дэлгэрүүлэх зорилготой сэтгүүлүүд болон янз бүрийн түвшний мэдээллийн сайтуудын

тусламжтайгаар оновчтой шийдвэрлэсэн байдаг. Тухайлбал, “Phys. Rev. D.”-ийн өгүүлэл зөвхөн мэргэжлийн хүмүүст зориулагдсан бол “Physics World” или “CERN Courier” -ийн өгүүллүүд ямар ч ажил эрхэлж буй аль ч физикчид ойлгомжтой. “Scientific American” шинжлэх ухааны асуудлыг сонирхдог дээд боловсролтой ямар ч хүнд хүртээмжтэй. Харин манай орны



Тодорхой мэргэжлийн эрдэмтэд, их дээд сургуулийн багш нарт зориулсан хялбаршуулан төрөлжсөн сэтгүүлийг ч олшруулах шаардлага бий. Ийм сэтгүүлүүд гаргахад санхүүгийн асуудал чухал гэдэг нь тодорхой. Үүнийг оновчтой менежментээр шийдэх боломжтой. Энэ асуудлыг англи хэлтэй орнуудад шинжлэх ухааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилготой сэтгүүлүүд болон янз бүрийн түвшний мэдээллийн сайтуудын тусламжтайгаар оновчтой шийдвэрлэсэн байдаг



хувьд өргөн хүрээг хамарсан, тооны хувьд хангалттай материал агуулсан, хэвлэгдэх хувийн хувьд олон түмэнд хүртээмжтэй, хэвлэгдэх давтамжийн хувьд харьцан-гуй шуурхай тогтмол хэвлэлийн сүл-жээ үгүйлэгдсээр өнөөг хүрсэн байдаг. Ер нь шинжлэх ухааны тухай хялбар-шуулсан түвшинд өгүүлдэг тогтмол хэвлэлийн систем маш чухал гэдэг нь үүнээс тодорхой харагддаг. Эс тэгвэл алдаа мадагтай, мэргэжлийн бус нэр томъёог агуулсан,

ер нь шинжлэх ухааны нээлтийн мөн чанарын талаар буруу зөрүү өгүүлсэн материалуудыг хүлээж авсаар байх болно.

- Олон хүний хувьд шинжлэх ухааны ямар ч нээлтийн тухай бэлтгэлгүй сонсогчид хүртэл өгүүлж болно гэдэг нь аксиом байдаг. Хэрэв тэгж хүргэх боломжгүй бол тухайн шинжлэх ухааны үр дүн зөвхөн явцуу хүрээний мэргэжилтнүүдийн асуудал бөгөөд энэ талаар ярих хэрэггүй гэж үздэг. Гэхдээ асуудлын гол нь өөр зүйлд байна. Мэргэжлийн бус бидний хувьд цөөнгүй судалгааны чухал үр дүнгүүд болон нээлтүүд ямар ч хүртээлгүй өнгөрдөг. Энэ бол юуны өмнө тэднийг үнэлэх, хүлээж авах бидний мэдлэг, оюуны чадавх дутмаг байгаатай холбоотой юм.
- Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх үйл явц олон үе шаттай бөгөөд үе шат болгонд бид ихэнх тохиолдолд зарим чухал зүйл нь ороогүй үлдсэн хэт энгийн хялбаршуулсан материалыг хүлээж авдаг. Мөн зохиогчийн хувьд материалыг шилж сонгох шаардлага гардаг. Ийм сонголтын үед түүний хариулт өгдөг түгээмэл асуултын нэг нь: "Би ямар зүйлийг нарийвчлан авч үзэж, яаж хялбаршуулсан аргаар хүргэж чадах вэ?" байдаг. Энэ нь түгээн дэлгэрүүлэгчийн бэлтгэл хангалтгүй байгаагаас ямар нэгэн зүйл олон нийтэд хүрэхгүй үлдэх шалтгаан болдог.
- Сэтгүүлчийн мэдлэг боловсрол, ур чадвартай холбоотой асуудлыг нэлээд суурь шинжтэй гэж хэлж болно. Шинжлэх ухааны соёлыг дээшлүүлэх чухал элемент бол материалын агуулгыг өндөр түвшинд боловсруулах, илэрхийлэх боломж юм. Ихэнх шинжлэх ухааны нөөц боломж нь, ялангуяа интернэтэд нээлттэй

байгаа нөхцөлд энэ бол тийм ч хүндрэлтэй асуудал биш. Үүнээс гадна хялбаршуулсан өгүүлэмж хамгийн сүүлчийн шатны үнэнийг агуулж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүй байх нь чухал. Энэ бол шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэхэд нөлөөлдөг чухал элемент бөгөөд үүнийг санаатай, санамсаргүй орхих тохиолдол цөөнгүй тааралддаг. Түүнчлэн боловсон хүчнийг буюу өндөр боловсролтой, тал бүрийн мэдлэгтэй шинжлэх ухааны сэтгүүлчдийг бэлтгэхэд анхаарах шаардлагатай.

Дүгнэлт. Шинжлэх ухааны сэтгүүл зүйн тулгамдсан асуудал бол нарийн төвөгтэй эсэхийг харгалзан материалыг янз бүрийн түвшинд бэлтгэх, мөн материалыг уншигчдад энгийн хүртээмжтэй хэлбэрээр илэрхийлэх явдал юм. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд янз бүрийн түвшний шинжлэх ухааны хялбаршуулсан сэтгүүлүүдийг бий болгох шаардлагатай. Боловсон хүчинтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх нь нэлээд нарийн төвөгтэй бөгөөд энд юуны өмнө сэтгүүлч боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэх асуудлыг болон шинжлэх ухааны соёлыг дээшлүүлэх шаардлагатай.

Эшлэл

- ¹ Ариунзаяа Н. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж. УБ., 2014. х.87.
- ² Баасансүрэн Т. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ., 2009. х. 26.
- ³ Зулькафиль М., Чойсамба Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ., 2005. х.33-34.
- ⁴ Пичугина Т.Что каждый журналист должен знать о науке, а каждый ученый – о журналистике//<http://humanism.al.ru/ru/articles.phtml?num=000148>

- ⁵ Штепа В. Научная журналистика в современном мире // “Акценты: Новое в журналистике и литературе”. 2007. №3-4. с.60.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ариунзаяа Н. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж. УБ., 2014.
2. Баасансүрэн Т. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ., 2009.
3. Дэлэг Г. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл (Хоёр дахь хэвлэл). УБ., 2014.
4. Зулькафиль М. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ., 2013.
5. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2013.
6. Зулькафиль М., Чойсамба Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ., 2005.
7. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ., 2000.
8. Норовсүрэн Л. Монголын нийтлэл. Тэргүүн боть. УБ., 2004.
9. Пичугина Т. Что каждый журналист должен знать о науке, а каждый ученый

– о журналистике // <http://humanism.al.ru/ru/articles.phtml?num=000148>

10. Штепа В. Научная журналистика в современном мире // “Акценты: Новое в журналистике и литературе”. 2007.

Резюме

Одним из ведущих направлений современной независимой журналистики является научная /научно-популярная/ журналистика. В результате интенсивного развития новой информационной технологии из года в год значение научной журналистики растёт. Автор опираясь на научно-теоретические концепции и выводы исследователей массовой коммуникации и практические опыты современных СМИ показывает особенности, значение и функции научной журналистики. Также автор статьи предлагает пути повышения действенности научно-популярных публикаций и передач СМИ.